



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.18 № 00/21 УАГ-ТАА/2013/25/ТАА-ТТЗ

Зөрчлийг арилгуулах тухай

Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газрын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад дараахь зөрчил илэрлээ.

- ХЗДХ-ийн сайдын баталсан “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх” журамд заасны дагуу Улсын байцаагч нарын өмсөж, хэрэглэх дүрэмт хувцас, хэрэглэлийг нийт ажиллагсдад хавтгайруулан олгож 44.1 сая төгрөгийн илүү зардал гаргасан
- 2012 онд 124.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь оны эцэст маягт хэвлүүлэх нэрээр 68.7 сая төгрөгийг 2 байгууллагад шилжүүлсэн,
- ТӨХ-оос зөвшөөрөл олгосон 4 авто машинаас гадна илүү 5 автомашиныг ашиглаж 25.1 сая төгрөгийн шатахуун, 11.4 сая төгрөгийн гражын төлбөр зэрэг нийт 36.5 сая төгрөгийн үргүй зардал гаргажээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасан “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулахын тулд акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэсэн заалтыг үндэслэн дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг өгч байна.

Дээрх зөрчлүүдийг арилган, давтан гаргахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч биелэлтийг 2013 оны 10 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газрын дарга Б.Пүрэвдорж, нягтлан бодогч Д.Мөнгөнцэцэг нарт даалгав.

АУДИТОР  ШИЧИНХОРЛОО



070069